



# СЭЗИС-ИЙН НЭРЭМЖИТ ЭКОНОМЕТРИКИЙН ДӨРӨВДҮГЭЭР ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ



## НЭГ. ОЛИМПИАДЫН ЗОРИЛГО

Оюутнуудын эконометрикийн онолын мэдлэгийг гүнзгийрүүлж, судалгаа, шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх, цаашид судалгаа, шинжилгээ хийх сонирхлыг нэмэгдүүлэх, эдийн засаг, санхүү, бизнесийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын эконометрикийн багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

## ХОЁР. ОРОЛЦОГЧИД

Эдийн засаг, санхүү, бизнесийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт суралцаж буй, эконометрикийн хичээл судалсан оюутнууд 3 хүнтэй баг бүрдүүлэн оролцох боломжтой.

## ГУРАВ. ОЛИМПИАДЫН АГУУЛГА

Олимпиад нь хүснэгтэд үзүүлсэн агуулгын хүрээнд явагдана.

№	Сэдэв	Эх сурвалж
1	Энгийн регрессийн шинжилгээ	Jeffrey M.Wooldridge, 5 <sup>th</sup> ed, "Introductory Econometrics" номын 1-9-р бүлэг, 17-р бүлэг
2	Олон хүчин зүйлийн шинжилгээ	
3	Нэг хэмжээст хугацааны цувааны шинжилгээ	Francis X.Diebold, 4 <sup>th</sup> ed, "Elements of Forecasting" ном Ruey S.Tsay, 3 <sup>rd</sup> ed, "Analysis of Financial Time Series" номын холбоотой бүлгүүд
4	Олон хэмжээст хугацааны цувааны шинжилгээ	Доорх номнуудын хоёр ба олон хэмжээст хугацааны цувааны шинжилгээний (ARDL, Хүлээлттэй загварууд, VAR, SVAR) загваруудын агуулга хамаарна: Walter Enders, 4 <sup>th</sup> ed, "Applied Econometrics Time Series" номын холбоотой бүлгүүд Ruey S.Tsay, (2014) "Multivariate time series analysis: with R and Financial applications" номын холбоотой бүлгүүд Maddala G.S., 3 <sup>rd</sup> ed, "Introduction to Econometrics" номын холбоотой бүлгүүд Gujarati N.Damodar, 5 <sup>th</sup> ed, "Basic econometrics" номын холбоотой бүлгүүд
5	Панел өгөгдлийн шинжилгээ	Jeffrey M.Wooldridge, 5 <sup>th</sup> ed, "Introductory Econometrics" номын 13-14-р бүлэг Jeffrey M.Wooldridge, "Econometric Analysis of Cross Section and Panel Data" номын холбоотой бүлгүүд
6	Инструментал хувьсагчийн үнэлгээ ба Хоёр шатат ХБК арга	Jeffrey M.Wooldridge, 5 <sup>th</sup> ed, "Introductory Econometrics" номын 15-р бүлэг

## ДӨРӨВ. ОЛИМПИАДЫН ҮЕ ШАТ

"Онолын мэдлэг сорих уралдаан", "Тоон шинжилгээ хийх аргазүй ба ур чадвар сорих уралдаан" гэсэн хоёр үе шаттайгаар олимпиад зохион байгуулагдана.

### I үе шат: Онолын мэдлэг сорих уралдаан

Дээрх хүснэгтэд үзүүлсэн агуулгын хүрээнд тест болон уламжлалт асуултаар сорил авч, багийн болон хувийн амжилтаар байр эзлүүлнэ. Энэ үе шатанд амжилттай оролцсон эхний 7 баг II үе шатанд оролцоно.

### II үе шат: Тоон шинжилгээ хийх аргазүй, ур чадвар сорих уралдаан

Энэ үе шатанд багуудаар эмпирик судалгаа хийлгэх, асуудал шийдвэрлүүлэх дараах хоёр даалгаврыг гүйцэтгүүлнэ. Үүнд: